



## Шинжээчийн тайлан

Байгууллагын нэр: Санхүү Эдийн Засгийн Их Сургууль

Хөтөлбөрийн нэр: Мэдээллийн систем

Индекс: D061303

Шинжээчийн баг:

Ахлагч: Н.Эрдэнэхүү / ШУТИС-ийн МХТС-ийн дэд захирал, доктор,  
профессор /

Гишүүд: Б.Баянмөнх / АШУИС-ийн Мэдээлэл технологийн албаны  
дарга, доктор, дэд профессор /

Л.Загдрагчаа/ Инфосистемс ХХК-ны захирал

Он сар өдөр: 2022.01.24

## **Агуулга**

### **Товчилсон үгийн тайлбар**

#### **I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт**

#### **II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга**

#### **III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт**

Шалгуур 1: Хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, нөөц

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйлчилгээ

Шалгуур 6: Багшлах бүрэлдэхүүн

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажуулалт

#### **IV. Уулзалтад оролцогчдын нэрс**

I. Багш нарын нэрс

II. Оюутнуудын нэрс

III. Ажил олгогчдын нэрс.

IV. Төгсөгчдийн нэрс

#### **V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал**

#### **VI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр**

#### **VII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр**

## Товчилсон үгийн тайлбар

- БСШУЯ Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яам
- СЭЗИС Санхүү Эдийн Засгийн Их Сургууль
- ШУТИС Шинжлэх ухаан технологийн их сургууль
- АШУИС Анагаахын шинжлэх ухааны их сургууль
- БМИҮЗ Боловсролын Магадлан Итгэмжлэх Үндэсний Зөвлөл
- ACM Association for Computing Machinery
- STEEP Social, Technological, Economic, Environmental, Political analysis Нийгэм, Технологи, Эдийн засаг, Хүрээлэн буй орчин, Улс төрийн үр нөлөөг тооцох чиг хандлагын шинжилгээний арга.
- УМС Удирдлагын Мэдээллийн Систем
- Lib4U Цахим номын сангийн платформ
- ACBSP Accreditation Council for Business Schools and Programs
- PEOs Program Educational Objectives-Хөтөлбөрийн боловсролын зорилтууд
- PLOs Program Learning Outcomes-Хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгүүд
- CLOs Course Learning Outcomes-Хичээлийн суралцахуйн үр дүнгүүд
- ҮДСБ Үр Дүнд Суурилсан Боловсрол
- EBSCO "Elton B. Stephens CO (company)" цахим сан
- ISCED-F-2013 Боловсролын олон улсын стандарт ангиллын боловсрол, сургалтын хөтөлбөр, мэргэшлийн чиглэлийн ангилал
- ЭЕШ Элсэлтийн Ерөнхий Шалгалт
- ЮНЕСКО Нэгдсэн үндэсний боловсрол, шинжлэх ухаан, урлагийн байгууллага
- ЭШХ Эрдэм Шинжилгээний Хурал
- PDCA Plan, Do, Check, Act-Төлөвлө, Гүйцэтгэ, Шалга, Сайжруул
- MOODLE Цахим сургалтын платформ
- ЕБС Ерөнхий Боловсролын Сургууль
- МХТ Мэдээлэл холбооны технологи
- ӨҮТ Өөрийн Үнэлгээний Тайлан

## I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

<b>Сургуулийн нэр /Монгол, Англи/</b>	Санхүү Эдийн Засгийн Их Сургууль	
<b>Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/</b>	“Мэдээллийн систем” бакалаврын хөтөлбөр	
<b>Индекс</b>	D061303	
<b>Шинжээчид</b>	<ol style="list-style-type: none"> <li>Н.Эрдэнэхүү-ШУТИС-ийн МХТС-ийн дэд захирал, доктор, профессор</li> <li>Б.Баянмөнх-АШУИС-ийн Мэдээлэл технологийн албаны дарга доктор, дэд профессор</li> <li>Л.Загдрагчаа-Инфосистемс ХХК-ны захирал</li> </ol>	
<b>БМИҮЗ-ийн Мэргэжилтэн</b>	Ж.Мөнхбилэг - БМИҮЗ-ийн магадлан итгэмжлэл хариуцсан мэргэжилтэн	
<b>Төлөвлөгөө</b>	<b>Он сар өдөр</b>	<b>Хийгдсэн байх ажлууд</b> /Мэргэжилтний гаргаж өгсөн хуваарийн дагуу бичнэ/
	12/14	Шинжээчийн багийг томилох
	12/16	Шинжээчидтэй гэрээ байгуулах
	12/14-16	Шинжээчдэд өөрийн үнэлгээний тайланг хавсралтын хамт хүлээлгэн өгнө.
	12/29	Шинжээчид урьдчилсан үнэлгээний тайланг мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.
	01/06, 07	Сургууль дээр очиж шинжээчид ажиллана.
	01/21	Шинжээчид үнэлгээний тайланг мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.
	01/25	Шинжээчдийн үнэлгээний тайланг сургуульд илгээж санал авна.
	01/26	Сургууль үнэлгээний тайлантай танилцаж, тайлбар, нотлох баримтыг мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.
	01/28	Шинжээчид үнэлгээний тайланг эцэслэнэ.
	02 сард	Мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар шинжээчийн үнэлгээний тайланг танилцуулж шийдвэрлүүлнэ.
<b>Шалгуур шаардлага /журам/</b>	БМИҮЗ-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 08 тоот тогтоолоор баталсан “Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн Магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журам”-ын “Сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн нийтлэг шалгуур шаардлага”	

## II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

СЭЗИС нь 1924 онд Гаалийн түр сургууль нэртэйгээр анх байгуулагдсан бөгөөд 1935 оноос Санхүү нягтлан бодох техникумын сургууль, 1946 оноос Санхүү эдийн засгийн техникум, 1991 оноос эдийн засгийн коллеж, 1996 оноос Санхүү эдийн засгийн дээд сургууль, 2016 оноос Санхүү эдийн засгийн их сургууль болж өргөжин хөгжиж ирсэн байна.

1964 онд 8 ширхэг тооцоолон бодох машин бүхий “Механикжсан цахилгаан тооцооны хичээлийн кабинет” байгуулагдсанаар одоогийн мэдээллийн системийн менежментийн тэнхим байгуулагдсан гэж үздэг юм байна. Энэ тэнхим 2005 оноос мэдээллийн системийн мэргэжлээр бизнесийн удирдлагын бакалаврын зэрэг олгох хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд 2014 оноос ЮНЕСКО-оос гаргасан ISCED-F-2013 индексийн ангилал дагуу “Мэдээллийн систем” хөтөлбөрөөр мэргэжилтэн бэлтгэдэг болсон байна.

Хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагаатай холбоотой гол гол тоон үзүүлэлтүүдийг өөрийн үнэлгээний тайлан болон сургууль дээр ажиллах үед танилцсан нотлох баримтад үндэслэн 2021 оны байдлаар хураангуйлан үзүүлэв. Үүнд:

- Бакалаврын хөтөлбөр-Мэдээллийн систем /4 жил, 130 кредит/
- Олгох зэрэг-Бизнесийн удирдлагын бакалавр
- Хөтөлбөрийн магадлан итгэмжлэлд орсон тоо- Анх удаа
- Сургалтын хөтөлбөрийн шинэчлэлд баримталж байгаа үндсэн зарчим:
  - Алсын хараа-2050, Боловсрол-2030 зэрэг төрөөс баримталж байгаа урт хугацааны бодлого төлөвлөлтүүдтэй нийцүүлэх
  - СЭЗИС-ийн стратеги төлөвлөгөө (2021-2031)-нд нийцүүлэх
  - БШУС-ын А/174 тоот “Сургалтын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага” зэрэг холбогдох бичиг баримтуудад нийцүүлэх
  - АСМ(Association for Computing Machinery) байгууллагаас гаргасан мэдээллийн систем хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэхэд тавигдах шаардлагууд бүхий жишиг санал зөвлөмжид нийцүүлэх
  - Хөтөлбөрт оролцогч талуудын санал хүсэлтийг тусган, тасралтгүй сайжруулах тогтолцоо
  - Оюутан төвтэй, идэвхтэй сургалтын технологийг баримтлах
- Хөтөлбөрийн боловсролын зорилтууд
  - Ерөнхий нэг өгүүлбэрээр томъёолсон
- Хөтөлбөрийн хүрэх үр дүн буюу суралцахуйн үр дүнг тодорхойлсон байдал
  - СЭЗИС-ийн хэмжээнд мөрдөх хувь хүний буюу зөөлөн ур чадварууд-7 үзүүлэлтээр тодорхойлсон
  - Мэдээллийн систем хөтөлбөрийн чиглэлд эзэмших мэргэжлийн мэдлэг, ур чадварууд—6 үзүүлэлтээр тодорхойлсон
- Сургалтын төлөвлөгөөний хичээл/кредитийн хуваарилалт:
  - Ерөнхий суурь-34 кредит, 26%
  - Мэргэжлийн суурь-31 кредит, 24%
  - Мэргэшүүлэх-65 кредит, 50%
- Сургалтад ашиглаж байгаа сургалтын болон үнэлгээний аргууд:
  - Сургалтын аргууд-4
  - Хүргэх хэлбэрүүд-9

- Үнэлгээний аргууд-Рубрик үнэлгээний аргууд, хичээлийн гарц үр дүнгийн тайлан шинжилгээ, Инфосис мэдээллийн системд суурилсан хичээлийн суралцахуйн үр дүн шинжилгээ хийх арга
- Сургалтын төлөвлөгөөнд байгаа дадлагын хичээл:
  - Дадлага олгох хичээл, төслийн тоо-5
  - Нийт кредит-5
  - Танилцах дадлага-5 долоо хоног
  - Мэргэжлийн дадлага-6 долоо хоног
- 2020-2021 оны идэвхтэй суралцаж байгаа оюутны тоо-123
- 2020-2021 оны элсэгчдийн тоо-66
- ЭЕШ-ын дундаж оноо-610
- 2020-2021 оны байдлаар шилжсэн, чөлөө авсан, хасагдсан, хөтөлбөр, мэргэжил сольсон оюутны тоо-36
- Сүүлийн 5 жилд шилжин ирсэн оюутны тоо-7
- Төгсөгчдийн тоо-90 гаруй
- Сүүлийн 5 жилийн нийт төгсөгчдийн/мэргэжлийн ажил эрхлэлтийн хувь-84/88%
- Сургалтын орчин, лаборатори, анги танхим:
  - Хичээлийн байрны тоо-4
  - 50-аас дээш суудалтай хурлын танхим-4
  - Номын сангийн уншлагын танхим-4
  - Номын сангийн суудлын тоо-260
  - Цахим номын эх үүсвэр-5 /EBSCO гэх мэт/
  - Номын сангийн программ-LiB4U
  - Мэргэжлийн лаборатори-9
  - Сургалтад ашиглаж байгаа компьютерын тоо-200 гаруй
  - 160 суудалтай оюутны цайны газар-1
  - Сургуулийн интернэт сүлжээний хурд-300Мб/с
  - Цахим сургалтын платформ-MOODLE
  - Удирдлага мэдээллийн систем-Инфосис, веб суурьтай систем
- Мэргэжлийн тэнхимийн тоо-1
- Үндсэн багшийн тоо-8
- Эрдмийн зэрэгтэй багш нарын эзлэх хувь-25%
- Гадаад, дотоодод докторантурт суралцаж буй багш нарын тоо-2
- Сүүлийн 3 жилд дотоод, гадаадад ЭШХ-д оролцсон, мэргэжил дээшлүүлсэн багш нар/давхардсан тоогоор/-24
- Профессор багш нарын 2014-2020 онд гүйцэтгэсэн ЭША-ын гол үр дүн:
  - Хэрэглээний чиглэлээр-57 ажил
  - Нэгтгэн уялдуулах-23 ажил
  - Сургалтын чиглэлээр-19 ажил
  - Имфакт фактор бүхий сэтгүүлд хэвлүүлсэн өгүүллийн тоо-3
  - Хэвлүүлсэн сурах бичиг, гарын авлага-7
  - Нэг сэдэвт бүтээл-6
  - Эрдэм шинжилгээний илтгэл-27
  - Бүтээлийн ишлэл-74
- Мэргэжлийн байгууллага, холбоонуудтай хамтран ажилладаг чиглэлүүд-4
- 2016 оноос хойш оюутан солилцоо, тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдсан оюутны тоо-25
- Оюутны сайн дурын клубийн тоо-23

- Сайн дурын клубт хамрагдсан мэдээллийн систем хөтөлбөрийн оюутны эзлэх хувь-19%
- Сүүлийн 5 жил тэтгэлэг урамшуулалд хамрагдсан оюутны тоо/олгосон урамшуулал-177/167 сая төгрөг

3 хүний бүрэлдэхүүнтэй шинжээчдийн баг хөтөлбөрт үнэлгээ хийсэн бөгөөд дараах давуу талуудыг онцолж байна. Үүнд:

- ✚ СЭЗИС нь 2005 оноос тус хөтөлбөрөөр мэргэжилтэнд бэлтгэж эхэлсэн, энэ хугацаанд сургалтын хөтөлбөр тасралтгүй, тогтвортой хэрэгжиж иржээ.
- ✚ МХТ-ийн хөгжлийн чиг хандлагатай уялдуулан санхүү, эдийн засаг, менежментийн чиглэлийн чадамжийг мэдээллийн системийн чиглэлийн чадамжтай хослуулан олгож байгаагаараа онцлог байна. Энэ нь зарим талаар ажлын байранд гарах үед давуу тал болдог нь уулзалт ярилцлагуудаас харагдаж байна.
- ✚ Тус сургууль 2012 онд олон улсын магадлан итгэмжлэлийн ACBSP байгууллагаар магадлан итгэмжлүүлсэн ба энэ хүрээнд сургалтын үйл ажиллагаанд хийсэн шинэчлэл нь өнөөгийн тогтолцоо бүрдэх, өөрийн гэсэн чанарын соёл төлөвших нөхцөлийг бүрдүүлсэн байна.
- ✚ Сургалтын чанарын баталгаажуулалтын тогтолцоог багшийн зааж байгаа хичээлийн түвшинд суралцахуйн үр дүн талаас нь хүрсэн үр дүнг үнэлэх, түүнийг тасралтгүй сайжруулахад чиглэсэн байдлаар төлөвлөж, хэрэгжүүлж ирсэн нь үр дүнгээ өгсөн байна.
- ✚ Сургалтын орчин сайн, лаборатори, анги танхим хүрэлцээтэй, багш бүр хичээлээ сайн бэлтгэж, чанартай заадаг болох нь нотлох баримтууд, уулзалт ярилцлагуудаас харагдаж байна.
- ✚ EBSCO санг албан ёсны эрхтэйгээр авч хэрэглэж байгаа нь сургалт, судалгааны цахим орчин бүрдүүлэхэд томоохон ач холбогдолтой ажил болжээ.
- ✚ Төгсөгчдийн зөөлөн ур чадвар, тэр дундаа харилцааны ур чадвар өндөр түвшинд байгаа нь нэг давуу тал болж байна.

Магадлан итгэмжлэлийн 7 шалгуурын дагуу хөтөлбөрт үнэлгээ хийсэн дэлгэрэнгүй тайланг дараах бүлгээс уншиж танилцана уу.

---

### III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

#### Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

##### 1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

##### Илрэл нотолгоо:

- СЭЗИС нь 2005 оноос эхлэн мэдээллийн системийн менежмент, 2014 оноос эхлэн мэдээллийн систем хөтөлбөрөөр мэргэжилтэнд бэлтгэж ирсэн байна.
- Дэлхийн эдийн засгийн форумын тайлан, UNESCO байгууллагын тайлан, зөвлөмж, “Алсын хараа 2050” урт хугацааны хөгжлийн бодлого, Боловсрол 2030-Тогтвортой хөгжлийн зорилго, “Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн барометр-2019”, Харилцаа холбоо мэдээллийн технологийн салбарын хүний нөөцийн судалгаа, Төгсөгчдийн судалгаа, хэлэлцүүлэг, Ажил олгогчдын судалгаа, Элсэгчдийн тандах судалгаа, Гадаад орчны судалгаа, Олон улсын ажил мэргэжлийн ангилал, ACM/AIS Мэдээллийн системийн бакалаврын хөтөлбөрийн жишиг сургалтын төлөвлөгөө, CDIO стандарт аргазүйн зөвлөмжүүд зэрэг бичиг баримтууд, оролцогч талуудын судалгааг үндэслэн хөтөлбөрийн эрэлт хэрэгцээг тодорхойлж, оролцогч талуудын санаа зөвлөмжийг тусгасан байна.
- Хөтөлбөрийн эрэлт хэрэгцээ, төгсөгчийн чадамжийг тодорхойлох зорилгоор STEEP шинжилгээг хийсэн байна.

Шалгуурыг хангасан байдал: **Бүрэн хангасан**

##### Онцлог зүйл/Туршлага:

- Мэдээлэл, Харилцаа Холбооны Технологийн хөгжлийн чиг хандлагатай уялдуулан санхүү, эдийн засаг, менежментийн чиглэлийн чадамжийг мэдээллийн системийн чиглэлийн чадамжтай хослуулан олгож байгаагаараа онцлог байна.
- Энэ хөтөлбөрөөр Бизнесийн удирдлагын бакалаврын зэрэг олгож байгаа нь ACM байгууллагын IS2020 зөвлөмжийн 4.3.2 заалтын дагуу бизнес суурьтай сургууль мэдээллийн систем хөтөлбөр хэрэгжүүлэх ерөнхий шаардлагад нийцэж байна.

##### Анхаарах асуудал:

- Хэдийгээр Мэдээллийн систем хөтөлбөрийн эрэлт хэрэгцээг олон судалгаагаар тодорхойлсон хэдий ч бизнес суурьтай мэдээллийн системийн мэргэжилтэн Монгол улсын аль байгууллагад, ямар ажлын байранд хэрэгцээтэй байгаа, тэнд ажиллах мэргэжилтэнд ямар ур чадвар шаардлагатай талаар тодорхой үр дүн, тоо баримт гаргаагүй байна.

##### Зөвлөмж:

- Бизнес суурьтай сургуулийн мэдээллийн систем хөтөлбөрт хамаарах ACM байгууллагын IS2020 зөвлөмжийн шаардлагад нийцүүлэн ерөнхий суурь,



бизнесийн цөм агуулга, мэдээллийн системийн цөм агуулга, нээлттэй сонгон хичээлүүдийг дахин төлөвлөх нь зүйтэй гэж үзэж байна.

## **1.2 Хөтөлбөрийн зорилго**

Хөтөлбөрийн зорилго нь байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

### **Илрэл нотолгоо:**

- СЭЗИС-ийн стратеги төлөвлөгөө 2021-2031, алсын хараа, эрхэм зорилготой уялдуулан Хөтөлбөрийн Боловсролын Зорилтууд(PEOs) болон Хөтөлбөрийн Суралцахуйн Үр дүнгүүд(PLOs)-ийг тодорхойлсон байна.
- Ингэхдээ PEOs-ийг нэг томъёоллоор, PLOs-ийг сургуулийн хэмжээнд мөрдөх зөөлөн ур чадвар ба мэдээллийн систем хөтөлбөрийн мэргэжлийн мэдлэг, ур чадвар гэсэн байдлаар тус тус тодорхойлсон байна.
- Мэдээллийн систем хөтөлбөрөөр төгсөгчийн загварыг хувь хүний, техникийн, мэргэжлийн мэдлэг, ур чадвар гэсэн үзүүлэлтүүдээр тодорхойлон гаргасан байна.

**Шалгуурыг хангасан байдал:** [Бүрэн хангасан](#)

### **Анхаарах асуудал:**

- Хөтөлбөрийн боловсролын зорилтууд(PEOs) нь төгсөгчийн сургууль төгссөнөөс хойш 4-5 жилийн дараах чадамжийн хүрсэн байх түвшин гэдэг утгаараа тодорхойлогдоогүй байна.
- Хөтөлбөрийн боловсролын зорилтууд, суралцахуйн үр дүнгүүдийг хэрхэн өөрчилж шинэчилдэг, энэ мэдээллийг олон нийтэд хэрхэн хүргэдэг болох нь тодорхойгүй байна.

### **Зөвлөмж:**

- Төгсөгчийн загвар, PEOs, PLOs-ийг дахин сайжруулж оролцогч талуудын санал, зөвлөмжийг тусган баталгаажуулах
- Энэ мэдээллийг сургуулийн, тэнхимийн веб сайт, оюутны гарын авлага зэрэг мэдээллийн хэрэгсэл ашиглан нийтэд түгээх, ажил олгогч талд энэ талаар мэдлэг ойлголт өгөх талд анхаарч ажиллах.

## **1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд**

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

### **Илрэл нотолгоо:**

- Мэдээллийн систем сургалтын хөтөлбөрийг сайдын А/174 тоот тушаалаар батлагдсан “Сургалтын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага”-д нийцүүлэн 12 бүлэгтэйгээр боловсруулж СЭЗИС-ийн эрдмийн зөвлөлийн дэргэдэх хороогоор 19/12/17 өдөр хэлэлцүүлж батлуулсан байна.
- Хичээлийн хөтөлбөрийг сургуульд мөрдөж байгаа загвар стандартын дагуу боловсруулан батлуулж, дагаж мөрдөж ирсэн байна. Энэ хөтөлбөрт багш бүр

сургалтад ашиглах арга зүй, суралцагчийг үнэлэх үнэлгээг тодорхой тусгасан байна.

- 2020 оны сургалтын төлөвлөгөөгөөр суралцагч 130 кр судлах бөгөөд ерөнхий суурь, мэргэжлийн суурь, мэргэжлийн хичээлийн харьцаа(26:24:50) нь А/174 тушаалаар батлагдсан шаардлага(30:25:45)-д нийцэж байна.

**Шалгуурыг хангасан байдал:** Бүрэн хангасан

**1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ:** Бүрэн хангасан

## Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

### 2.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь суралцагч төвтэй, хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан байна.

#### Илрэл нотолгоо:

- Мэдээллийн систем хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөний хичээлүүд ба PLOs(13 үр дүн) хоорондын хамаарлыг тодорхойлсон байна.
- СЭЗИС-ийн Инфосис удирдлагын мэдээллийн системээр хичээл сонголт хийх боломж бүрдсэн.
- Сургалтын 1-8 дугаар улиралд 5 кредитийн 5 төрлийн дадлага, төслийн хичээлийг сургалтын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж ирсэн байна.
- Тайланд сургалтын төлөвлөгөөний хичээл хоорондын залгамж холбоог тодорхойлж зурагласан байна.
- Оюутны хичээл сонголт нэг улиралд 15-17 кредит байгаагаас харахад суралцагч хэвийн ачаалалтай гэж дүгнэхээр байна.
- Сургалтад идэвхтэй сургалтын 4 арга, 9 хүргэх хэлбэр ашиглахаар төлөвлөн сургалтын хөтөлбөрт тусгасан байна.

**Шалгуурыг хангасан байдал:** Бүрэн хангасан

#### Анхаарах асуудал:

- Хэдийгээр PLOs ба хичээлийн хамаарлыг гаргасан боловч тухайн хичээлээр эзэмших мэдлэг, ур чадвар, хандлага нь ямар түвшинд байхыг үйл үг талаас нь (Блумын таксаном гэх мэт) нарийн гаргаагүй байна.

#### Зөвлөмж:

- Орчин үеийн, оюутан төвтэй суралцахуйн идэвхтэй аргуудаас ямар ямар аргуудыг хичээлийн онцлогоос хамааруулан хэрхэн сонгож хэрэглэж байгаа, тэдгээрийн үр өгөөж ямар байгааг үнэлж дүгнэх шаардлагатай.

### 2.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй,

тасралтгүй сайжруулдаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Хичээлийн түвшинд суралцахуйн үнэлгээг Блумын таксаномд үндэслэн рубрик үнэлгээгээр гаргадаг.
- Хичээл бүрээр гарц үр дүнгийн тайланг гаргаж, үр дүнгээр хичээлийг тасралтгүй сайжруулдаг тогтолцоо бий болсон байна.
- Бакалаврын сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах журмын дагуу хичээлийн явцын болон улирал, төгсөлтийн шалгалтыг зохион байгуулдаг.
- Инфосис мэдээллийн системээр дамжуулан хичээл бүрийн үр дүн, үнэлгээнд дүн шинжилгээ хийх боломж бүрдсэн байна.

**Шалгуурыг хангасан байдал:** **Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Багшийн зааж байгаа хичээлийн түвшинд гарц үр дүнгийн тайланг тогтмол гаргаж, түүний үр дүнгээр хичээлийн үр дүнг тасралтгүй сайжруулж ирсэн нь үр дүнгээ өгсөн байна

#### **Зөвлөмж:**

- Хичээлийн түвшинд хийж байгаа гарц үр дүнгийн тайланг цаашид CLOs буюу хичээлийн суралцахуйн үр дүн бүрийг үнэлэх чиглэлд улам боловсронгуй болгон өөрчлөн сайжруулах нь зүйтэй.

**2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ:** **Бүрэн хангасан**

### **Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, нөөц**

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

#### **3.1 Сургалтын орчин**

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Стандартын дагуу хичээлийн талбай, байртай байна.
- 200 компьютер бүхий 9 лабораторитай.
- Суралцагчийн сэтгэл ханамжийн судалгааны үр дүнг үзүүлсэн ба сэтгэл ханамж 80%-аас дээш байна.
- Сургалтын цахим орчинг сайн бүрдүүлсэн.
- Сүүлийн 3 жилд хийгдсэн ажлын тайлангууд
- Багш нарын өрөө тасалгааны хангамж сайн

**Шалгуурыг хангасан байдал:** **Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- 200 компьютер бүхий 9 лабораторитой. Сургалт явуулах анги танхимын хүрэлцээ хангалттай, мэргэжлийн лабораторийн хүрэлцээ боломжийн.

- Эдгээр лабораторид ажиллаж байгаа багш нарын мэргэжлийн төвшин хангалттай, заах ур чадвар сайн.
- Багш нарын ажиллах орчин болох өрөөний багтаамж хангалттай
- Стандартын дагуу хичээлийн талбай, байртай байна.

#### **Анхаарах асуудал:**

- Зарим нэг лабораторийн өрөөнд ковид-19 цар тахлын үед ажиллахад шаардлагатай зай хэмжээ багатай, олон суралцагч зэрэг хичээллэхэд хүндрэлтэй байна. Хүн хоорондын зайг 1.5 метр зайтай болгох
- Сургалтын лабораториудын компьютеруудын орчин программ хангамжуудыг шаардлагад нийцүүлэн тогтмол шинэчлэх

#### **Зөвлөмж:**

- Мэргэжлийн хөтөлбөрийн ангийн оюутнуудад зориулсан өндөр хүчин чадал бүхий лаборатори бий болгох
- Судалгаа, санал асуулгын дагуу хийсэн ажлын үр дүнгийн талаар сургалтад оролцогч талуудад мэдээлдэг байх

### **3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн**

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Мэргэжлийн хичээлийн сургалтанд нээлттэй эхтэй болон лицензтэй программ хангамж ашиглаж байна.
- Одоо ашиглаж байгаа сургалтын хэрэглэгдэхүүн, программ хангамж, нөөцийн жагсаалтыг гаргасан.
- Сургалтын ажлыг зохион байгуулах заавар, удирдамж, зөвлөмжийг цахимаар бэлдэж багш оюутны системд байршуулсан байна.

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Лаборатори, материаллаг баазыг өөрийн хөрөнгөөр үе шаттайгаар шинэчилдэг.
- Сургуулийн орчинд утасгүй интернэт ашиглах боломжтой.

#### **Анхаарах асуудал:**

- Лабораториудын ашиглалтыг нэмэгдүүлэх үүднээс компьютеруудыг бүрэн бүтэн ажиллах боломжтой болгох
- Компьютероос гадна хичээлийн шаардлагад нийцүүлэн нэмэлт тоног төхөөрөмж, хэрэгслүүдээр хангаж тэдгээрийг ашиглах ур чадвар эзэмшүүлэх

#### **Зөвлөмж:**

- Суралцагчийн бие даан ажиллах орчныг нэмэгдүүлэх
- Сургуулийн утасгүй интернэт сүлжээний хурд, хамрах хүрээнд шинжилгээ хийж, хэрэгцээг хангах хэмжээнд шинэчлэн сайжруулах

### 3.3. Сурах бичиг, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

#### Илрэл нотолгоо:

- Номын сангийн фонд бүрдэлт сайн, мэргэжлийн сурах бичгийн баяжилт жил бүр хийгдэхэд тодорхой санхүүжилттэй.
- Фонд бүрдүүлэлтийн төсвийн тайланг гаргаж хавсаргасан байна.
- Эрдэм шинжилгээний нэгдсэн сан үүсгэсэн.
- Цахим мэдээллийн сан ашиглалт, хандалт сайн. Хөтөлбөрөөр суралцагчдын сэтгэл ханамжийн судалгааны үнэлгээг үзүүлсэн бөгөөд 75-85% буюу дунджаас дээш үнэлгээг өгсөн байна.
- EBSCO сантай, цахим сурах бичгийн санг ашигладаг.

#### Шалгуурыг хангасан байдал: **Бүрэн хангасан**

#### Онцлог зүйл/Туршлага:

- EBSCO санг албан ёсоор худалдан авч хэрэглэдэг.
- Номын сангийн фонд бүрдэлт сайн, мэргэжлийн сурах бичгийн баяжилт жил бүр хийгдэхэд зориулсан тодорхой санхүүжилттэй.
- Сургуулийн төв номын сангийн фондод гадаад хэл дээр байгаа мэргэжлийн сурах бичгийн тоо хангалттай.

#### Анхаарах асуудал:

- Монгол хэл дээрх мэргэжлийн цахим номын тоо цөөн.

#### Зөвлөмж:

- Монгол хэлээр мэргэжлийн хичээлүүдийн цахим сурах бичгийн тоог нэмэгдүүлэх

3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: **Бүрэн хангасан**

### Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчныг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежмент, маркетингийг хэрэгжүүлнэ.

### 4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

#### Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн хороо, тэнхимийн хурлын шийдвэр, тэмдэглэл

- Мэргэжлийн зөвлөх хороо нь СЭЗДС-ын захирлын тушаалын дагуу нийт 6 гишүүнтэйгээр 2 жилийн хугацаатайгаар ажилладаг. Хөтөлбөрийн хорооны бүтцийг үзүүлсэн байна.
- 2021.08.27-ны СЭЗИС-ын ректорын А/148 тушаал, Эрдмийн зөвлөлийн журмыг баримтлан ажилладаг.
- Хөтөлбөртэй холбоотой санал хүсэлтийг нээлттэй, цахимаар авах боломж бүрдүүлсэн.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх жил бүрийн тайланг захирлын зөвлөлөөр тайлагнадаг.
- Сургалтын нэгдсэн удирдлагын систем нийт 8 ангиллаар 18 дэд хэсгүүдийн багтаасан сургалтын нэгдсэн удирдлагын системийг ашиглан үйл ажиллагааг явуулдаг.
- Сургалт, эрдэм шинжилгээ, олон нийтэд чиглэсэн үйл ажиллагааны талаарх мэдээлэл 9 сувгаар дамжиж олон нийтэд хүрдэг.

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

##### **Онцлог зүйл/Туршлага:**

- Хөтөлбөртэй холбоотой санал хүсэлтийг нээлттэй, цахимаар авах боломж бүрдүүлсэн.
- Хөтөлбөрийн хэрэгжилтийн жил бүрийн тайланг захирлын зөвлөлөөр тайлагнадаг.
- Нийт 8 ангиллаар 18 дэд хэсгүүдийн багтаасан сургалтын нэгдсэн удирдлагын системийг ашиглан үйл ажиллагаа явуулдаг.
- Одоо ашиглаж байгаа системүүдээс 5 системийн интерфэйсийг тусгасан байгаагаас 3 нь лицензтэй программ хангамж ашигладаг.
- Сургалт, эрдэм шинжилгээ, олон нийтэд чиглэсэн үйл ажиллагааны талаарх мэдээлэл 9 сувгаар дамжиж олон нийтэд хүрдэг.

##### **Анхаарах асуудал:**

- Мэргэжлийн зөвлөх хороог хэзээ сүүлд шинэчлэгдсэн нь тодорхойгүй, журмын дагуу хуралддаг эсэх нь тодорхойгүй.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгчдийн урт хугацааны төлөвлөгөө байхгүй.

##### **Зөвлөмж:**

- Цахим сургалтын MOODLE, Инфосис системийг хандалт, хүртээмж, ачаалал талаас нь сайжруулах/Гэхдээ хөгжүүлэлт, сайжруулалт хийж байгаа/
- Мэргэжлийн зөвлөх хорооны үйл ажиллагааг сайжруулах

#### **4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ**

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

##### **Илрэл нотолгоо:**

- Бизнесийн болон мэдээллийн технологийн салбарын байгууллагуудтай 4 чиглэлээр хамтран ажилладаг.
- Дотоодын байгууллагуудтай мэргэжлийн үйл ажиллагаанд нь зөвлөгөө өгөх зарчмаар хамтран ажилладаг

- Оюутан солилцоо, тэтгэлэгт хөтөлбөрт 3 үндсэн журмын дагуу хамруулдаг байна. 2016 оноос хойш нийт 25 суралцагсад тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдсан байна.
- Нийт оюутнууд “Нийгмийн дадлага” сэдэвт дадлагыг 6 үндсэн чиглэлээр заавал хийдэг. Оюутнуудын 80% нь уг дадлагыг 1-2-р курстээ явуулах шаардлагатай гэж дүгнэжээ.
- Багш нар 2017 оноос 9-13 насныханд, 2021 оноос ахлах ангийнханд кодчиллын хөтөлбөр санаачлан хэрэгжүүлж ажиллаж байна.
- Төгсөгчид оюутнуудын дунд өдөрлөг зохион байгуулдаг. Харилцааны мэдээлэл солилцох групптэй.
- Төгсөгчдийн судалгааг 2021 оны 3 сард авсан. Нийт 62.7% нь хамрагдсан байна.

### Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

#### Онцлог зүйл/Туршлага:

- Бизнесийн болон мэдээллийн технологийн салбарын байгууллагуудтай 4 чиглэлээр хамтран ажилладаг.
- Дотоодын байгууллагуудтай мэргэжлийн үйл ажиллагаанд нь зөвлөгөө өгөх зарчмаар хамтран ажилладаг.
- Оюутан солилцоо, тэтгэлэгт хөтөлбөрт 3 үндсэн журмын дагуу хамруулдаг байна. 2016 оноос хойш нийт 25 суралцагсад тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдсан байна.
- Багш нар 2017 оноос 9-13 насныханд, 2021 оноос ахлах ангийнханд кодчиллын хөтөлбөр санаачлан хэрэгжүүлж ажиллаж байна.

#### Анхаарах асуудал:

- Гадаад дотоодын их дээд сургуулийн хамтын ажиллагааны гэрээний хүрээнд багш солилцооны хөтөлбөр хангалтгүй байна.
- Төгсөгчдийн холбооны үйл ажиллагааг сайжруулах/эхлэл төдий байна/.

#### Зөвлөмж:

- Төгсөгчдийн холбооны үйл ажиллагааг тогтмолжуулах, шинэ оюутнуудад зөвлөгөө өгөх ажлыг холбоогоор дамжуулан зохион байгуулах
- Багш солилцооны хөтөлбөрийн үйл ажиллагааг нэмэгдүүлэх

### 4.3 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

#### Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжийн жилийн төсөв, зарцуулалтын тайлан
- Нэг суралцагчид ноогдох өртөг зардлын тооцоо
- Сургалтын төлбөрөөс хөтөлбөрт зарцуулагддаг хувь хэмжээ, үр дүнгийн судалгаа
- Хөтөлбөрийн хүрэх үр дүнд чиглэгдсэн шинэчлэлт, өөрчлөлтөд зориулсан төсөв, төсвийн зарцуулалт
- Төр, хувийн хэвшлийн дэмжлэг, санхүү түүний зарцуулалтын тайлан
- Санхүүгийн эх үүсвэр тогтмол, 2020 оноос элсэгчийн тоо нэмэгдэж байгаатай уялдан орлого болон сургалтын зардал нэмэгдэж байна.

- Хүснэгт 4-11-д орлогод эзлэх зардлын хувь 103.99%-иас 73.86% болтол буурсан байна.
- Нэг суралцагчдад ноогдох өртөг зардал 2021 онд 146.814 байна.
- 2016-2017 онд хөтөлбөрт зарцуулсан зардал нь орлогоосоо өндөр байсан боловч 2017 оноос 85-94%-ийг зарцуулж байна.

**Шалгуурыг хангасан байдал:** [Бүрэн хангасан](#)

**Онцлог зүйл/Туршлага:**

- Санхүүгийн эх үүсвэр тогтмол, 2020 оноос элсэгчийн тоо нэмэгдэж байгаатай уялдан орлого болон сургалтын зардал нэмэгдэж байна.

**Зөвлөмж:**

- Мэргэжлийн үйл ажиллагаанаас олох орлогыг нэмэгдүүлэх

#### **4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт**

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

**Илрэл нотолгоо:**

- Тандан судалгаа, дүгнэлт, холбогдох материал
- Хийсэн ажил, арга хэмжээ, тайлан, баримт
- Элсэлтийн веб сайтаараа дамжуулан үндсэн мэдээллээ дамжуулдаг.
- Жил бүр уламжлал болгон 9 чиглэлээр олон нийтэд таниулах ажлыг зохион байгуулдаг.

**Шалгуурыг хангасан байдал:** [Бүрэн хангасан](#)

**Онцлог зүйл/Туршлага:**

- Элсэлтийн веб сайтаараа дамжуулан үндсэн мэдээллээ дамжуулдаг.
- Жил бүр уламжлал болгон 9 чиглэлээр олон нийтэд таниулах ажлыг зохион байгуулдаг.
- Элсэлтийн тоо эрс нэмэгдсэн.

**Анхаарах асуудал:**

- Өөрсдийн хэрэгжүүлж буй бусад хөтөлбөрүүдээс ялгагдах онцлогийг илүү тодорхой гаргаж өгөх, элсэгч болон ажил олгогчдод сурталчлах

#### **4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал**

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

**Илрэл нотолгоо:**

- Жил бүр мэргэжлийн ЭШХ, үзэсгэлэн яармагт оролцон тэнхимийн үйл ажиллагааг сурталчилдаг. Тайлант хугацаанд багш нар 4 ЭШХ-д оролцсон байна.
- Вэбсайтын мэдээллийн иж бүрэн байдал, тогтмол ажиллагаатай. Хөтөлбөрийн үйл ажиллагааны талаар сүүлийн үеийн мэдээллийг сургуулийн веб сайт, нийгмийн сүлжээгээр цахим хэлбэрээр, сонин хэвлэл, сургуулийн, хэвлэмэл хэлбэрээр мэдээлдэг.

**Шалгуурыг хангасан байдал:** [Бүрэн хангасан](#)



### Онцлог зүйл/Туршлага:

- Мэдээллийн систем хөтөлбөрийн үйл ажиллагааны талаар сүүлийн үеийн мэдээллийг сургуулийг веб сайт, нийгмийн сүлжээгээр цахим хэлбэрээр, сонин хэвлэл, сургуулийн, сургалтын албаны зарлалын самбар дээр хэвлэмэл хэлбэрээр тогтмол мэдээлдэг.

4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ [Бүрэн хангасан](#)

### Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйлчилгээ

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

#### 5.1. Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

#### Илрэл нотолгоо:

- Элсэлтийн тоог хангалттай хэмжээнд хүргэхийн тулд тэнхимээс сүүлийн жилүүдэд нэлээд анхаарч сургуулийн албан ёсны мэдээллийн суваг, боловсролын үзэсгэлэн яармаг, нээлттэй хаалганы өдөрлөг гэх мэт өөрийн боломжит арга замаас гадна бусад олон төрлийн сувгийг ашиглан мэдээллийг хүргэж байна.
- Сүүлийн 5 жилд тус тэнхимийн хөтөлбөрт элссэн суралцагчдын тоо нэмэгдсэн бөгөөд ЭЕШ-ын дундаж оноо ойролцоо түвшинд байгаа нь суралцагчдад тавих шаардлагыг тогтмол түвшинд барьж чадаж байгааг харуулж байна.

Шалгуурыг хангасан байдал: [Бүрэн хангасан](#)

#### 5.2. Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

#### Илрэл нотолгоо:

- Шинээр элсэн суралцагчдад зөвлөн туслах үйлчилгээ, гарын авлага мэдээлэл хангалттай сайн байгаа нь нотлох баримтаас харагдаж байна.
- Оюутны хөгжлийн төвийн талаар хийсэн оюутнуудын сэтгэл ханамжийн судалгааны үр дүн харьцангуй тогтвортой байна.
- Суралцагчдад зориулсан төрөл бүрийн сургалт, ААНБ-тай хамтран оюутнуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, дадлагажуулах, ажлын байраар хангах талаар тогтмол үйл ажиллагаа явуулж байгаа нь сайшаалтай байна.
- Сургуулиас зохион байгуулдаг “Оюутны эрдэм шинжилгээний хурал”-д тэнхимийн оюутнуудыг хамруулж, амжилттай оролцож байна.

Шалгуурыг хангасан байдал: [Бүрэн хангасан](#)

#### Анхаарах асуудал:

- Оюутнуудад зориулсан Инфосис программын ажиллагаа шалгалтын үед болон ачаалал ихтэй, яг чухал үед гацдаг үүнээс болж хичээлийн сонголтод хүссэн

хичээлүүдээ сонгож авч чадаагүй гэх мэт сөрөг үзэгдлүүд гарч оюутнууд хохирдог байдал цөөн биш тохиолддог. Ийм учраас сургуульд дотооддоо хэрэглэж байгаа Moodle, Инфосис програмууд нь болхи удаан, ачаалал даадаггүй, тухайн оюутанд хамааралгүй мэдээллүүд харагддаг гэх мэт дутагдалтай талуудыг яаралтай засаж сайжруулах хэрэгтэй байна. Энэ талаар оюутнууд санал хүсэлт гаргадаг боловч олигтой шийдэгддэггүй юм байна.

- Сургалтын хөтөлбөр 4 жилийн өмнө Монголын бусад их дээд сургуулиудын хөтөлбөрөөс түрүүлж явж байсан боловч одоо яг хаана, аль түвшинд явааг дахин нэг дүгнэж, сургалтын хөтөлбөрийн мэдээллийн технологийн орчин үеийн чиг хандлагад нийцүүлэн зайлшгүй шинэчлэх шаардлагатай байгааг төгсөгчидтэй хийсэн уулзалтын үеэр олон хүн хэлж байлаа. Сургалтын хөтөлбөрт хиймэл оюун ухааны (AI) талаар хичээл нэмж оруулах зайлшгүй шаардлагатай гэж үзсэн.
- Оюутнуудад багаар ажиллах, ачаалал даах, асуудлыг бие даан шийдвэрлэх чадвар олгох сургалтын агуулга, арга хэлбэрийг сонгож, мэргэжлийн олон хичээлүүдийн уялдаа холбоог хангасан, мэдлэгийг ашигласан дадлагыг сургалтын хөтөлбөрт оруулахад онцгой анхаарах нь чухал байна.

#### **Зөвлөмж:**

- Оюутны хөгжлийн төвийн талаар оюутнуудын сэтгэл ханамжийн судалгаа харьцангуй тогтвортой байгаа боловч бага зэргийн бууралт нь зөвхөн цар тахлын нөлөөтэй юу эсвэл өөр шалтгаан байна уу гэдгийг нарийн тодруулах, өөр төрлийн судалгааг дахин авах шаардлагатай. СЭЗИС-аас жил бүр “Оюутны эрдэм шинжилгээний хурал”-ыг 2 салбартайгаар зохион байгуулдаг. Салбар 2-оос Бизнесийн удирдлага, Мэдээллийн системийн менежмент-ийг тусад нь гаргаж бие даасан салбар 3 болгож зохион байгуулбал илүү үр дүнтэй харагдаж байна.
- Оюутнуудад үйлдвэрлэлийн дадлага хийх байгууллагуудыг тэнхимийн зүгээс олж өгдөг, санал болгодог, тусалж дэмждэг байх, хамтран ажилладаг байгууллагуудын жагсаалт гаргаж санал болгодог байх.
- 3-р курсээс нь биш 1-р курсээс мэргэжлийн хичээл заадаг, мэргэжлийн хичээлүүд дээр лабораторийн ажил хийлгэдэг болбол үйлдвэрлэлийн дадлагын үр дүнг сайжруулах, улмаар төгсөгчдийн мэдлэг чадвар, чанарыг сайжруулах.
- Moodle, Инфосис програмуудын серверийг ачаалал даах хэмжээнд шинэчлэх, тохиргоо хийж сайжруулах, цахим хэсгийг засаж сайжруулах, шаардлагатай тохиолдолд өөр систем ашиглах.
- Төгсөгчдийн холбооны үйл ажиллагааг идэвхжүүлж, суралцагчидтай уулзалт, сургалт хийх, оюутнуудад мэргэжлийн орчин чиг хандлага, боломжийг таниулах, мэргэжлийн чиглэлээ сонгох, карьераа төлөвлөхөд туслах (мэргэжлийн аль чиглэлд ажиллах, түүний тулд ямар хичээлүүдийг онцгойлон судлах) гэх мэт хамтын ажиллагааг өргөн хүрээнд тогтмол зохион байгуулж байх.

#### **5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшуулал**

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Сургуулийн хэмжээнд оюутны сайн дурын 23 клуб үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд хамрагдаж байгаа оюутнуудын 19% нь тус тэнхимийн оюутнууд байна.

- Нийгэмд чиглэсэн олон ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Эх сурвалж: ЭКО СЭЗИС-оюутнуудын оролцоо (сургуулийн веб сайтаас)
- Жил бүр зохион байгуулдаг Хакатон, банкны холбоотой хамтран хэрэгжүүлсэн эрдэм шинжилгээний хурал, Startup Weekend Mongolia зэрэг хөтөлбөрт амжилттай оролцсон.
- Сүүлийн 5 жилийн хугацаанд давхардсан тоогоор 177 оюутныг 167 сая гаруй төгрөгийн хөнгөлөлт, буцалтгүй тусламж, зээл, шагналд хамруулсан нь суралцагчдын урамшуулах сайн тогтолцоотой байгааг харуулж байна.

**Шалгуурыг хангасан байдал:** [Бүрэн хангасан](#)

**Онцлог зүйл/Туршлага:**

- IT Мэргэжлийн клубийн үйл ажиллагааны хүрээнд 2 Startup шинээр эхлүүлж, үйл ажиллагаа нь тогтвортой явж байгаа нь сайшаалтай байна.

#### **5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн**

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

**Илрэл нотолгоо:**

- 5 жилийн өмнө шилжсэн, чөлөө авсан, хөтөлбөр, мэргэжил сольсон оюутнуудын тоо нийт оюутны 31% байсан ба түүнээс хойших хугацаанд 10-17% болж буурсан нь харьцангуй тогтвортой болсныг харуулж байна.

**Шалгуурыг хангасан байдал:** [Бүрэн хангасан](#)

#### **5.5. Төгсөлтийн баримт бичиг**

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

**Илрэл нотолгоо:**

- Төгсөлтийн баримт бичиг, баталгаажуулалт нь стандартад нийцсэн байна.

**Шалгуурыг хангасан байдал:** [Бүрэн хангасан](#)

**5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ:** [Бүрэн хангасан](#)

## **Шалгуур 6. Багшлах бүрэлдэхүүн**

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

#### **6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого**

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

### **Илрэл нотолгоо:**

- Багш сонгон шалгаруулахдаа СЭЗДС-ийн захирлын 2015 оны 1 дүгээр 19-ний өдрийн 039 тоот тушаалаар батлагдсан “СЭЗДС-ийн дотоод журам”-ын 2 дугаар бүлгийн “багш, ажилтан, ажилчин ажилд авах, ажлаас чөлөөлөх, халах” тухай заалтыг үндэслэн ажилладаг.
- СЭЗИС-ийн үндсэн орон тооны “Багш” зэрэглэлийн албан тушаалтан нь “Багшийн хөдөлмөр, түүнийг үнэлэх, дүгнэх журам”-ын дагуу 38 кредит цагийн хөдөлмөрийн норм, багшийн зэрэглэлээс хамаарч А, В, С цагийн нормтой байдаг.
- Хүний нөөцийн тогтвортой, ажилдаа сэтгэл ханамжтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэхийн тулд сонгон шалгаруулалт, ажилд томилох, тавигдах шаардлага, урамшууллын тогтолцоо, мэргэжил дээшлүүлэх боломжоор нь хангах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байна. Дагаж мөрдөх журам заавар, бодлогын баримт бичиг хангалттай байна.
- Сүүлийн жилүүдэд 1 багшид ноогдох суралцагчдын харьцаа 5-6 байгаа нь багш, суралцагчдын тооны харьцаа хэвийн байгааг харуулж байна.
- Багшийн хөдөлмөр, түүнийг үнэлэх дүгнэх журамд заасан багшийн албан тушаалын зэрэглэлд тавих шаардлагыг хангасан тохиолдолд А, В, С цагийн гүйцэтгэлийг үнэлэн дүгнэж багшийн болон тэнхимийн саналыг үндэслэн албан тушаалын зэрэглэл ахиулдаг. Сүүлийн 5 жилийн хугацаанд сургуулийн хэмжээнд 56 багш зэрэглэл ахисан байна.
- Сургуулийн хэмжээнд Багшийн хөдөлмөр, түүнийг үнэлэх дүгнэх журам, эрдэм шинжилгээний бүтээлийн үзэсгэлэн зохион байгуулах, шилдэг тэнхим, шилдэг баг, багш шалгаруулах, багш ажилтнуудын цалин хөлс, шагнал урамшуулал, хөнгөлөлт, хангамжийн журам, багш ажилтнуудыг шагнал урамшуулалд тодорхойлох журмууд зэрэг урамшууллын сайн тогтолцоотой байна. Сургууль нь багш ажилтны идэвх санаачилга, тэдний амжилттай ажиллах хүсэл сонирхол, хэрэгцээ шаардлагад үндэслэсэн шагнал урамшуулал, хөнгөлөлт халамж, буцалтгүй тусламжийг сургуулийн “Дотоод журам”-ын хүрээнд шийдвэрлэн ажилладаг.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

### **Онцлог зүйл/Туршлага:**

- Докторын ажил хамгаалахад сургуулиас 30% санхүүжилт өгөөд сургалт дууссаны дараа үр дүнд үндэслэн 100% зардал даадаг.
- Боловсон хүчнийг ажилд авах, нөөцийг бүрдүүлэх тогтолцоо сайн бүрдсэн, сургуулийн орчин нөхцөл, хамт олны уур амьсгал сайн учраас зөв ажилтанаар багаа бүрдүүлж чадсан байна.
- Ажлаа уян хатан төлөвлөж чаддаг, зохицуулах боломжтой байдаг учраас багш өөрийгөө хөгжүүлэх, судалгаа шинжилгээний ажил хийх, орлогоо нэмэгдүүлэх, ажил амьдралаа зохицуулах, ажилдаа сэтгэл ханамжтай, стрессгүй хандах сайн нөхцөлийг бүрдүүлж өгдөг юм байна.
- Сургуулийн удирдлагын тогтолцоо олон шат дамжлагагүй учраас аливаа асуудлаар санал шүүмжлэлийг найрсгаар хүлээж авч, шуурхай шийддэг. Ингэснээр богино хугацаанд менежмент хийх боломжтой болжээ.

### **Анхаарах асуудал:**

- Мэдээллийн системийн менежментийн тэнхимийн докторын зэрэгтэй багш нарын эзлэх хувийн сургуулийн дунджаас (29%) бага байгаа (25%) нь анхаарах ёстой үзүүлэлтийн нэг гэж бодож байна. 2005 оноос энэ хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн нь шинэ тутам салбар гэж үзэх үндэслэлгүй байна.
- Сүүлийн 15 жилийн хугацаанд өмнө олгодог байсан багш нарын нийгмийн асуудлыг шийдэхэд олгодог байсан 6-9 сая төгрөгийн дэмжлэгийг олгохоо больсныг одоо үргэлжлүүлэх шаардлагатай гэсэн саналууд гарсан.
- Сургалтын эрэлт хэрэгцээний талаар дахин судалгаа авч, сургалтын агуулгыг багш нарын хэрэгцээ шаардлага, орчин үед нийцүүлэн шинэчлэх шаардлагатай байна.
- Мэдээллийн системийн менежментийн тэнхимийн нийт багш нарын 70% нь багш болон ахлах багш зэрэглэлд ажиллаж байгаа бөгөөд тайлант хугацаанд дунджаар 20-30 кредит А цагийн гүйцэтгэлтэй байна. Цагийн ачааллын дунджийг сургуулийн багш зэрэглэлийн нормтой харьцуулахад ойролцоогоор 30%, ахлах багш зэрэглэлийн нормтой харьцуулахад 47% орчим хувиар илүү ачаалалтай байгаа нь харагдаж байна.
- Багш нарын хувьд ажилдаа дур сонирхолтой, байгууллагын соёл сайн, Монголын хамгийн дээд институтэд ажилладаг гэж бодож явдаг учраас ажлаа сольё, гаръя гэсэн бодол байхгүй, учраас ачаалал ихтэй байх тусмаа зүгээр байдаг гэж ярилцлагын явцад хэлсэн. Гэвч энэ байдлаараа удвал урамшууллын бодлого ямар байгаагаас үл хамааран хүний нөөцийн тогтвортой байдал алдагдахад хүргэх сөрөг талтайг анхаарууштай.

### **Зөвлөмж:**

- 1 багшид ноогдох оюутны тоо олон улсын дунджаар 12-15 байдагтай харьцуулбал энэ тэнхимийн ачаалал сүүлийн жилүүдэд 5-6 байгаа нь харьцангуй бага бөгөөд докторантурт суралцаж эрдмийн зэргээ ахиулахад багш болон сургуулийн талаас зохицуулах бүрэн боломжтой байна. Цаашид доктор зэрэгтэй багш нарын эзлэх хувийг нэмэгдүүлэх тал дээр анхаарах.
- Багш нарын мэргэжил, мэдлэгийг дээшлүүлэх, ачааллыг тэнцүү хуваарилах, хичээлийн агуулга, бүтэц, багш нарын ур чадварт дүн шинжилгээ хийж, энэ талаар арга хэмжээ авч ажиллах.
- Багш нарын орон сууцны нөхцөлийг сайжруулах, нийгмийн асуудлыг шийдэхэд анхаарлаа хандуулж, хөнгөлөлт, урамшуулал олгох зэргээр сургуулийн түвшинд бодлого гаргаж ажиллах

### **6.2. Багшийн хөгжил**

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

### **Илрэл нотолгоо:**

- 2018-2021 он хүртэл багшийн мэргэжлийн мэдлэг, гадаад хэл, судалгаа шинжилгээний зөвлөгөө өгөх, багшлах арга зүй, хувь хүний хөгжил, МХТ-ийг хэрэглэх чадварын сургалтуудын талаар Хүснэгт VI-7-д хавсаргаж ирүүлсэн байна.
- Мэдээллийн системийн менежментийн тэнхим нь багшлах бүрэлдэхүүний ур чадвар, хэрэгцээ, сургуулийн стратеги зорилгод нийцүүлэн 2018-2021 оны хүний нөөцийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж байгаа бөгөөд материалд хавсаргасан төлөвлөгөөний хэрэгжилттэй танилцав.

- Жил бүр багш нар сургалтын болон хувийн хөгжлийн төлөвлөгөөг дэлгэрэнгүйгээр гаргаж ажилладаг бөгөөд уг төлөвлөгөөн дээр үндэслэн тэнхимийн ажлын төлөвлөгөөг гаргаж жилийн эцэст ажлын гүйцэтгэлийг дүгнэдэг.
- Эрдмийн зэргийн сургалт, эрдэм шинжилгээний хурал, семинар, конференцэд хамруулсан байдал хангалттай байна.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**

- 2021 оноос эхлэн тэнхим тус бүрд өөрийн төсвөө бие даан шийдэж зарцуулах эрхийг шилжүүлсэн нь багш нар сургалтын зардлаа шуурхай шийдүүлэх боломжтой болсон дэвшилттэй зөв шийдвэр болжээ.

**Анхаарах асуудал:**

- Мэдээллийн технологийн хурдацтай хөгжлийн эрин зуунд багш нарыг гадаад, дотоодод мэргэжил дээшлүүлэх, шинэ технологи, мэдээллийн системийн менежментийн чиглэлээр сургалтад хамруулсан байдал хангалтгүй байна.
- Багш нарын хэрэглэдэг дотоодын системээс багш нар өөрсдөө гарц үр дүнгийн судалгаагаа авах боломжийг нээж өгөх шаардлагатай байна. Одоо зөвхөн эрх бүхий албан тушаалтнууд л энэ мэдээлэлд хандах эрхтэй байгаа. Багш нар өөрийн үнэлгээний тайланг бичихийн тулд өгөгдөл олж авахад ихээхэн хүндрэлтэй байна.

**Зөвлөмж:**

- Багшийн хөгжлийн төрөл бүрийн сургалт, семинар тогтмол явуулдаг боловч зах зээлийн эрэлт хэрэгцээ, орчин үеийн чиг хандлагад бүрэн нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх. Судалгаа авч эргэх холбоогоо сайжруулах хэрэгтэй.
- Багш нарыг гадаадад сургах, багш солилцооны гэрээнүүд хийгдсэн байдаг боловч яг хэрэгжүүлэх асуудал орхигдсон тул цаашид анхаарч, хэрэгжүүлэх.

### **6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа**

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

**Илрэл нотолгоо:**

- БСШУ-ын сайдын 2020/05/29-ны өдрийн А/270 тоот тушаалаар баталсан “Дээд боловсролын сургалтын байгууллагын багшид тавигдах нийтлэг шаардлага батлах тухай”, Дээд боловсролын тухай хууль, СЭЗИС-ийн ректорын 2019/10/06-ны өдрийн А/147 тоо тушаалаар баталсан “СЭЗИС-ийн Хүний нөөцийн бодлогын баримт бичиг”, СЭЗИС-ийн ректорын 2018/02/13-ны өдрийн А/051 тоот тушаалаар баталсан “Багшийн хөдөлмөр, түүнийг үнэлэх, дүгнэх журам” шинэчилсэн найруулга, “СЭЗИС-ийн багш, оюутны суралцахуйн үр дүнг үнэлэх журам” зэрэг дүрэм журмуудыг баримтлан ажилладаг.
- СЭЗИС болон гадны байгууллагын санхүүжилттэй 19 төсөлд мэдээллийн системийн тэнхимийн багш нар оролцсон байна.
- Доктор Д.Болормаагийн 3 судалгааны ажил нь өнөөдрийн байдлаар олон улсад 60 (тайланд 43) удаа эшлэгдсэн, доктор Л.Эрдэнэсайхан 4 судалгааны бүтээл өнөөдрийн байдлаар олон улсад 56 (тайланд 31 ) удаа эшлэгдсэн байна.
- Сүүлийн 5 жилийн хугацаанд хэрэглээний чиглэлийн эрдмийн ажил 57, нэгтгэн уялдуулах эрдмийн 23 ажил, сургалтын чиглэлээр 19 эрдмийн ажил тус тус хийж

гүйцэтгэсэн байна. Мөн судалгааны нэг сэдэвт бүтээл 6, хянах магадалгаатай ЭШХ, семинарын эмхэтгэл 30, ном сурах бичиг, гарын авлага 7, эрдэм шинжилгээний хуралд 7 илтгэл, хянан магадалгаатай сэтгүүлд 7 эрдэм шинжилгээний бүтээл тус тус гаргажээ.

- Жил бүр сургуулиас зохион байгуулдаг эрдэм шинжилгээний хуралд 15 сая төгрөг, 2018 оныг дуустал судалгааны төсөлт ажилд ойролцоогоор 48-141 сая төгрөг, багшийн хөгжилд 90 гаруй сая төгрөг буюу нийт төсвийн 3-4%-ийг төсөвлөж иржээ.

**Шалгуурыг хангасан байдал:** [Бүрэн хангасан](#)

**Зөвлөмж:**

- Багшийн хөгжилд төсөвлөсөн мөнгөөр (90 сая төгрөг) гадаадад мэргэжил дээшлүүлэхэд ихээхэн чамлалттай байгаа учраас цаашид нэмэгдүүлэх, хамтран ажилладаг сургуулиудтай болох, хамтын ажиллагааны хүрээнд сургалтад явуулж мэргэжил дээшлүүлэх, тэтгэлэг гэх мэт бусад санхүүжилтийн эх үүсвэрийг хайх, сертификаттай богино хугацааны онсайт болон цахим сургалт гэх зэрэг сургалтын өөр арга хэлбэрийг хайж, хэрэгжүүлэх.

#### **6.4. Багшийн үнэлгээ**

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

**Илрэл нотолгоо:**

- Багшийн хөдөлмөрийг үнэлэхдээ СЭЗИС-ийн ректорын 201802/13-ны өдрийн А/051 тоот тушаалаар баталсан “Багшийн хөдөлмөр, түүнийг үнэлэх, дүгнэх журам” болон түүний нэмэлт өөрчлөлтийн 8.5-д заасны дагуу чанарын үнэлгээг хийдэг.
- Сүүлийн 4 жилийн байдлаар тэнхимийн чанарын үнэлгээ 81%-аас дээш буюу “Маш сайн” гэж гарсан нь багш нарын чанарын үнэлгээ хангалттай түвшинд байна гэж ойлгож болохоор байна.
- Багш бүр хувийн хөгжлийн төлөвлөгөөгөө боловсруулан, хичээлийн жилийн эцэст өөрийн хөгжлийг үнэлэн дүгнэлт гаргадаг юм байна. Багшийн өөрийн үнэлгээний тайланг тэнхимийн эрхлэгч үнэлж, нэгтгэсэн үнэлгээг сургалт эрхэлсэн дэд захиралд танилцуулан тэнхимийн ирэх хичээлийн жилийн үйл ажиллагааны болон СЭЗИС-ийн хүний нөөцийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийг боловсруулах үндэслэл болгодог.
- 2022 оны хичээлийн жилээс эхлэн багш өөрийн үнэлгээний тайлангийн аргачлал, дүгнэх дүрэм журмыг шинээр боловсруулан үйл ажиллагаандаа ашиглахаар бэлтгэл ажлаа хангасан байна.

**Шалгуурыг хангасан байдал:** [Бүрэн хангасан](#)

**6-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ:** [Бүрэн хангасан](#)

#### **Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажуулалт**

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.



### **7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт**

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

#### **Илрэл нотолгоо:**

- СЭЗИС-ийн түвшинд сургалтын үйл ажиллагааны чанарт шинжилгээ хийж тасралтгүй сайжруулах тогтолцоог орц, үйл явц, гарцын хувьд төлөвлөж, хэрэгжүүлж ирсэн байна.
- 2020 оны 11 сарын 06-ны өдрийн захирлын тушаалаар баталсан журмыг чанарын дотоод баталгаажуулалтад мөрдөж ажиллаж байна.
- Оролцогч талуудыг багш, оюутан, дунд шатны удирдлага, мэргэжилтэн, дээд шатны удирдлага, мэргэжлийн зөвлөх хороо, гадаад оролцогч талууд гэсэн байдлаар гаргаж, тус тусын үүргийг тодорхойлсон байна.
- Чанарын баталгаажуулалтыг хичээл, мэргэжил, хөтөлбөрийн түвшинд хэрхэн зохион байгуулах төлөвлөлтийг хийж, хичээл талдаа илүү үр дүнтэй хэрэгжүүлэлт хийж ирсэн байна.

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Чанарын баталгаажуулалт хариуцсан нэгжийг албан ёсоор байгуулахгүйгээр хичээлийн түвшинд гарц үр дүнг үнэлэх, үр дүнг шат шатанд хэлэлцүүлэн тасралтгүй сайжруулах тогтолцоог мөрдөж ирсэн нь онцлог байна.

#### **Зөвлөмж:**

- Одоо мөрдөж байгаа чанарын дотоод баталгаажуулалтын тогтолцоог илүү үр ашигтай болгох, үнэлгээний үр дүнгээр үйл ажиллагаа хэрэгжүүлэх шат дамжлагыг багасгах үүднээс бүтэц зохион байгуулалтын хувьд зарим нэг сайжруулалт хийх нь зүйтэй гэж үзэж байна.

### **7.2. Хөтөлбөрийн үр дүн**

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна..

#### **Илрэл нотолгоо:**

- Мэдээллийн систем хөтөлбөрөөр төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгаа 5 жилээр гаргахад дундаж ажил эрхлэлт 84%, мэргэжлээрээ ажил эрхлэлт 88% гэж гарсан байна.
- Төгсөгчдийн ажлын байраар хангагдах хүртэл хүлээх хугацааг 2013-2019 оны төгсөгчдийн хувьд гаргаж дундаж хугацаа 2.3 сар байгааг тогтоожээ.
- Сэтгэл ханамжийн судалгааг оюутан, ажил олгогч гэсэн үзүүлэлтээр гаргаж тайланд тусгасан ба үр дүн хангалттай түвшинд гарчээ.
- Төгсөгчдийн зөөлөн ур чадвар, тэр дундаа харилцааны ур чадвар өндөр түвшинд байгаа нь оролцогч талуудтай хийсэн уулзалтаас харагдаж байлаа.

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Анхаарах асуудал:**



- Хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгийн гүйцэтгэлийн түвшнийг PEOs, PLOs, CLOs-ийн хувьд хийсэн төлөвлөлт байгаагаас бус үнэлгээний бодит үр дүнг PEOs, PLOs-ийн хувьд гараагүй байна.

**Зөвлөмж:**

- Хичээлийн гарц үр дүнгийн тайланг суралцахуйн үр дүн бүрээр гаргахад анхаарах, PEOs, PLOs-ийн хувьд тодорхой давтамжтайгаар гүйцэтгэлийн болон ач холбогдлын үнэлгээ хийж тасралтгүй сайжруулахад анхаарах

**7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх**

Шаардлагатай бол олгож буй эрдмийн зэрэг болон мэргэжлийн нэр хүндийг дэмжих зорилгоор үндэсний болон олон улсын байгууллагаар хөндлөнгийн үнэлгээ хийлгэдэг байна.

**Илрэл нотолгоо:**

- Мэдээллийн систем хөтөлбөр өмнө нь дотоодод магадлан итгэмжлэл хийлгэж байгаагүй боловч тус сургуулийн санхүү, менежментийн чиглэлийн бусад хөтөлбөрүүд ACBSP байгууллагаар олон улсад магадлан итгэмжлэх ажлын хүрээнд чанарын дотоод баталгаажуулалтаар тасралтгүй сайжруулалт хийгдэж ирсэн байна.

**Шалгуурыг хангасан байдал: [Бүрэн хангасан](#)**

**Онцлог зүйл/Туршлага:**

- Тус сургууль 2012 онд олон улсын магадлан итгэмжлэлийн ACBSP байгууллагаар магадлан итгэмжлүүлсэн ба энэ хүрээнд сургалтын үйл ажиллагаанд хийсэн шинэчлэл нь өнөөгийн тогтолцоо бүрдэх, өөрийн гэсэн чанарын соёл төлөвших нөхцөлийг бүрдүүлсэн байна.

**Анхаарах асуудал:**

- Төгсөгчдийг мэргэжлийн салбарт хэрхэн хүлээн зөвшөөрч байгаа, төгсөгчид мэргэжлийн шалгалтуудад хэрхэн хамрагдаж ямар амжилт үзүүлсэн талаар судалгаа, мэдээлэл байхгүй байна.
- Тус хөтөлбөрийн төгсөгчид гадаад, дотоодод ахисан түвшний сургалтад хэр хамрагдаж байгаа талаар судалгаа, үр дүн байхгүй байна.

**Зөвлөмж:**

- Цаашид мэдээллийн систем хөтөлбөрт хөндлөнгийн үнэлгээ хийлгэх, олон улсын түвшинд магадлан итгэмжлүүлэхэд анхаарах

**7-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: [Бүрэн хангасан](#)**

## ДУГНЭЛТ

Шалгуур		Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангаагүй (0)	Үндэслэл, шалтгаан /хэсэгчлэн хангасан болон хангаагүй шалгуурт заавал бичнэ/
1	Хөтөлбөрийн төлөвлөлт	+			
2	Сургалтын үйл ажиллагаа	+			
3	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, нөөц	+			
4	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	+			
5	Суралцагчид чиглэсэн үйлчилгээ	+			
6	Багшлах бүрэлдэхүүн	+			
7	Чанарын үнэлгээ, баталгаажуулалт	+			
<b>Дүгнэлт</b>		<b>Бүрэн хангасан</b>			

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг СЭЗИС-ийн “Мэдээллийн систем” хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул **“ШАЛГУУРЫГ БҮРЭН ХАНГАСАН”** гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг Мэдээлэл, харилцаа холбооны технологи чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

## НЭГДСЭН ЗӨВЛӨМЖ, ШААРДЛАГА

<b>Сургуулийн нэр</b>	Санхүү Эдийн Засгийн Их Сургууль
<b>Хөтөлбөрийн нэр</b>	Мэдээллийн систем
<b>Хөтөлбөрийн индекс</b>	D061303
<b>ЗӨВЛӨМЖ</b>	
Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт	<ul style="list-style-type: none"> <li>➤ Хэрэгжүүлж байгаа хөтөлбөр нь бусад их дээд сургуулийн үндсэн хөтөлбөртэй харьцуулбал санхүү, эдийн засаг, менежмент, бизнесийн удирдлага талын болон мэдээллийн систем талын чадамжийг нэгэн зэрэг олгож байгаа хөтөлбөр учраас энэ онцлогийг харгалзан олон улсын стандарт шаардлагад нийцүүлэн сайжруулах нь зүйтэй.</li> </ul>
Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> <li>➤ Үр дүнд суурилсан боловсролын онол арга зүйн дагуу хөтөлбөрөөр эзэмших суралцахуйн үр дүнгүүд, тэдгээрт тохирох орчин үеийн суралцахуйн болон заахуйн арга зүй, хүргэх хэлбэрүүд, мөн суралцагчийн чадамжийг сургалтын явцад болон төгсгөлд үнэлэх тохиромжтой үнэлгээний аргууд нь харилцан шүтэлцээтэй гурвалжин байдлаар төлөвлөгдөж хэрэгжих ёстой. Иймээс сургалтын үйл ажиллагааг энэ зарчимд тулгуурлан оновчтой төлөвлөх, хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах.</li> </ul>
Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, нөөц	<ul style="list-style-type: none"> <li>➤ Сургалтын орчны өнөөгийн хүрсэн түвшнийг сайжруулахын тулд сургалтад ашиглаж байгаа орчин үеийн программ хангамж, хэрэгслүүдийг тоог нэмэгдүүлэх, лицензжүүлэх;</li> <li>➤ Цахим сургалтын платформ болон сургалтын удирдлага мэдээллийн системийн найдвартай ажиллагааг дээшлүүлэх;</li> <li>➤ Утасгүй интернэт сүлжээний хурд, хамрах хүрээг нэмэгдүүлэх.</li> </ul>
Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	<ul style="list-style-type: none"> <li>➤ Мэргэжлийн зөвлөх хорооны үйл ажиллагаа сайжруулж, тэдний санал зөвлөмжийг сургалтын хөтөлбөрийн эрэлт хэрэгцээ тодорхойлох, сургалтын хөтөлбөрийг тасралтгүй сайжруулахад тусгах ажлыг тогтмолжуулах;</li> <li>➤ Төгсөгчдийн холбооны үйл ажиллагааг сайжруулж сонгодог утгаар ажиллуулах.</li> </ul>
Шалгуур 5. Суралцагчдад чиглэсэн үйлчилгээ	<ul style="list-style-type: none"> <li>➤ Элсэлтийн маркетингийг сайжруулах, сурталчилгааг олон хэлбэрээр зохион байгуулах;</li> <li>➤ Шинээр элссэн оюутнуудыг мэргэжилд нь дур сонирхолтой болгох, хөтөлбөрийн онцлог давуу талуудыг ойлгуулах, удиртгал хичээл, төслийн хичээлүүдийг сургалтын төлөвлөгөөнд нэмэлтээр тусгах.</li> </ul>
Шалгуур 6. Багшлах бүрэлдэхүүн	<ul style="list-style-type: none"> <li>➤ Багшийн хангамжийг нэмэгдүүлэх, эрдмийн зэрэг цол хамгаалах ажлыг бодлогоор дэмжиж ажиллах;</li> <li>➤ Гадаад дотоодын их дээд сургуулийн хамтын ажиллагааны гэрээний хүрээнд багш солилцооны хөтөлбөрийн үр өгөөжийг дээшлүүлэх.</li> </ul>
Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажуулалт	<ul style="list-style-type: none"> <li>➤ Хөтөлбөрийн үр дүнг бүх түвшинд буюу PEOs, PLOs, CLOs-ийн түвшинд тодорхой давтамжтайгаар үнэлэх, зорилтот түвшинд хүрэхгүй байгаа үр дүнгүүдийг PDCA зарчмаар тасралтгүй сайжруулах</li> </ul>

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэг ...../Н.Эрдэнэхүү/

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг...../ Б.Баянмөнх /

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг...../ Л.Загдрагчаа /

#### IV.Ярилцлагад оролцогчдын нэрс

##### I. Багш нарын нэрс

№	Нэр	Албан тушаал	Утас	Ажилл асан	Заадаг хичээл
1	Н.Саранчимэг	Тэнхимийн эрхлэгч	99902286	8	Бизнес шинжилгээ
2	Д.Болормаа	Профессор	99161990	34	Системийн шинжилгээний зохиомж
3	Ц.Гүндэгмаа	Ахлах багш	99066863	15	Өгөгдлийн мангийн удирдлага
4	Л.Эрдэнэсайхан	Ахлах багш	80809009	12	Объект программчлал
5	Ш.Ганболд	Ахлах багш	98000990	34	Алгоритм программчлалын хэл
6	Б.Бат-Оргил	Ахлах багш	99042420	16	Алгоритм программчлалын хэл
7	Г.Эрдэнэцэцэг	Багш	90950605	8	Интернет программчлал
8	А.Ууганбаяр	Дадлагажигч багш	88086843	6	Бизнес шинжилгээ

##### II. Оюутны нэрс

№	Оюутны нэрс	Курс	Утас
1	С.Энхжин	4	95961515
2	Б.Бадамдорж	4	88097727
3	Э.Нямдорж	4	99099278
4	Г.Энхсүлд	4	89887811
5	Д.Амарболд	3	99203333
6	Б.Баатарсүрэн	3	98091066
7	А.Хишиг-Учрал	3	89909486
8	Ө.Амгалан	3	85807773
9	Э.Тэмүүлэн	3	99158767
10	М.Хулан	2	89792133
11	Б.Батнасан	2	95802438
12	БТүвшинбаяр	2	89898814
13	Б.Хүслэн	2	89985727
14	Б.Алтаншагай	2	99228583
15	С.Балжинням	1	88598874
16	С.Удвал	1	86265225
17	Г.Төгөлдөр	1	95919212
18	Д.Номин-Эрдэнэ	1	98874001

III. Ажил олгогчдын нэрс

№	Овог нэрс	Байгууллага	Утас
1	С.Хонгорзул	Голомт банк	90909060
2	Л.Өлзийсайхан	Үндэсний дата төв	88111978
3	Б.Нямцэрэн	Дижитал Воркс ХХК	88099599
4	Э.Энхбаяр	Эффишэнтвэй ХХК	99126921
5	Ж.Амаржаргал	Орчард Консалтинг ХХК	99114024
6	С.Янжмаа	Ашид капитал ХХК	88019812

IV. Төгсөгчдийн нэрс

№	Овог нэрс	Төгссөн он	Байгууллага	Утас
1	Алтайбаатар	2011	Монре даатгал	88060744
2	Номингарав	2011	Интек ХХК	88018021
3	Хулан	2013	Эффишэнтвэй ХХК	88054805
4	Номуужин	2020	Ашид капитал ХХК	99451230
5	Цогтсайхан	2018	Голомт банк	99150861
6	Балжинням	2017	Дижитал воркс ХХК	88447170
7	Цацрал	2012	Хас банк	99608146
8	Батсүх	2013	Intelligent Finance ХХК	89019073
9	Болорчимэг	2015	Интек ХХК	99878317
10	Ганжидмаа	2017	Юнител	88250059
11	Батцэцэг	2015	АШУИС	89224400
12	Ичинхорлоо	2018	Ашид капитал ХХК	97111099
13	Аззаяа	2015	ТЭСО ХХК	90044499
14	Бум-Эрдэнэ	2021	Мевенто ХХК	86106033
15	Э.Гажидваанчиг	2013	Юнител	89114580
16	Б.Баясгалан	2015	Новел Софт ХХК	99051859
17	А.Соронзонгомбо	2015	Рио Тинто	99204774
18	Б.Энх-Учрал	2021	Колл про ХХК	86897070

**V.Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал**  
/албан бичгийг оруулах/



**САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН  
ИХ СУРГУУЛЬ**

13381 ш/х-49, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,  
Энхтайвны өргөн чөлөө 5, Утас/Факс: (976-11) 45 83 78,  
И-мэйл: info@ufe.edu.mn, Вэбсайт: www.ufe.edu.mn

2022.01.28 № 05/043

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

Харну хүргүүлэх тухай

БМИҮЗ-ИЙН ДЭД ДАРГА,  
АЖЛЫН АЛБАНЫ ЗАХИРАЛ  
О.ЯНЖМАА ТАНАА

Бид танай байгууллагаас 2022 оны 01 сарын 25-ны өдөр албан мэйлээр ирүүлсэн Мэдээллийн систем D061303 индекстэй бакалаврын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлд хөндлөнгийн үнэлгээ хийсэн шинжээчийн багийн үнэлгээний тайлантай танилцлаа.

Магадлан итгэмжлэл хариуцсан ажлын хэсэг, Мэдээллийн систем, менежментийн тэнхимийн хамт олон, Мэдээллийн систем бакалаврын хөтөлбөрийн өөрийн үнэлгээний баг БМИҮЗ-ийн шинжээчдийн багийн өгсөн үнэлгээ, зөвлөмжүүдтэй санал нийлж байгаа ба цаашид хөтөлбөрийн хэрэгжүүлэлтэд тусган ажиллах болно.

Магадлан итгэмжлэлийн үйл ажиллагаанд хамтран ажиллаж буй танд болон танай хамт олонд талархал илэрхийлж, ажлын өндөр амжилт хүсье.

РЕКТОР



Б.МӨНХБАЯР

## ҮI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан(огноо) .....  
[Мэргэжлийн зөвлөлийн хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

**Зөвлөмж/Recommendations/**

## ҮII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Магадлан итгэмжлэх комиссын хуралдаан(огноо)  
..... [Магадлан итгэмжлэх комиссын хэлэлцүүлгийн  
дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

**Зөвлөмж/Recommendations/**